

ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөлийн мэдээлэл

ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөлөөс 2020 оны 10 сарын 29-ний өдөр “Ёс суртахууны боловсрол” семинарыг зохион байгуулав.

Семинарт МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, хүмүүнлэгийн ухааны салбарын Философи, шашин судлалын тэнхимийн зөвлөх профессор Р.Дарьхүү оролцож, ёс зүй, ёс суртахуун, мэргэжлийн ёс зүй, багшийн ёс зүйн агуулгын хүрээнд ёс суртахууны талаарх мэдлэг ойлголт, хэм хэмжээ, харилцаа, ёс суртахуунлаг үйлдэл, ёс суртахууны үүрэг хариуцлага, ёс суртахуунлаг багш, мэргэжилтний талаар мэдлэг мэдээллээ хуваалцлаа.

ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн асуудал, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд даган мөрдөж буй “ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн дүрэм”-ийн талаарх мэдлэг ойлголтыг нэмэгдүүлэх, “ШУТИС-2030 стратеги төлөвлөгөө”, “Багшид тавигдах нийтлэг шаардлага”-д нийцүүлэн дүрмийн нэмэлт, өөрчлөлтийн санал авах ажлыг нийт бүрэлдэхүүн сургуулийн багш, ажилтан, ажиллагчдыг хамруулан зохион байгууллаа.

ШУТИС-ийн Багш, ажилтны ёс зүйн зөвлөл